

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Дотоод хяналт	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	0
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Л.ЭНХБАЯР
ТАНАА

201 № 06/450
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар кассын няравын ажлыг хавсран гүйцэтгэдэг, санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулаагүй, өмнөх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын захирал Л.Энхбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох хууль, бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 28-наас 2019 оны 03 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн аудитор А.Цэрэнчимэд, хяналтын менежер Б.Баттулга нар хариуцаж хэрэгжүүлэв.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 19/60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Аудит
хийхэд

Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ нь Олон улс, тив, дэлхийн тэмцээн уралдаан, соёл урлагийн арга хэмжээ хурал зөвлөгөөнийг эх орондоо өндөр түвшинд зохион байгуулах, ордныг үр ашигтай ажиллуулж, зөв удирдлага менежментээр удирдан, дэлхийн жишигт хүргэж хөгжүүлэх, эрхэм зорилготой байна.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биеийн тамир, спортын талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах
- Төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилгыг хэрэгжүүлэх

- Иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, спорт чийрэгжилтийн арга хэмжээ болон олон улс, тив, дэлхийн тэмцээнийг зохион байгуулах
- Соёл урлагийн болон бусад арга хэмжээг зохион байгуулах

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд дараах шинэчлэлт, өөрчлөлт гарсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 30-ны 477 дугаар тогтоолоор Буян-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын бүтэц, албан тушаалыг шинэчлэн баталжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Leader-3” програм хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант хугацааны нийт зардлын дүнг сонгов.

Тайлант хугацааны нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт зардал санхүүгийн тайлагналын үндсэн үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны нийт зардлын дүн 1,881,9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 37,6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан, төлөвлөлтийн шатанд эрсдэлийн үнэлгээний түвшин дунд гэж тодорхойлогдсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлээ. Үүнд:

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй хураангуй бүртгэл, анхан шатны баримтыг иж бүрдэл, хүчин төгөлдөр байдлыг шалгахад кассын тайлан, агуулахын бүртгэл хөтлөөгүй байсныг аудитын явцад залруулсан.
- Аудитын явцад 64 нэрийн үндсэн хөрөнгөнд хамаарах тавилга, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нягтлан бодох бүртгэл, тайланд тусгагдаагүй байсныг 45,6 сая төгрөгөөр үнэлүүлж, данс бүртгэлд тусгуулав.
- Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 онд хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн 458,6 сая төгрөгийг өмчийн дүнд оруулан тайлагнасан байсныг залруулж, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлж, залруулав.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

/Сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	248,6	
2	Албан шаардлага өгсөн	1	112,2	
	Дүн	3	360,8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

Буянт -Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангаар 27 харилцагчтай холбоотой 93,5 сая төгрөгийн авлага, 1 харилцагчтай холбоотой 18,6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Үүнээс шүүхийн шатанд 4 байгууллагын 6,2 сая төгрөгийн авлага байна.

Энэ нь “Оршин байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал” батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баритмжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Тайлант хугацаанд тооцоо үүссэн харилцагч тус бүрээр тооцоо нийлсэн акт үйлдэж байх албан шаардлага хүргүүлэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус компани сүүлийн 3 жил дараалан 822,0– 398,9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 2018 онд авлага 78,4 сая төгрөг, өр төлбөр 123,1 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Иймд тус компанийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, бүтэц зохион байгуулалтын оновчтой шийдэл гаргах шаардлагатай нь аудитын явцад ажиглагдсан.

Тус компанийн захирлын 2018 оны контракт гэрээг 2019 оны 3 дугаар сарын 12-ны байдлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар дүгнүүлээгүй, 2018 оны үйл ажиллагааны тайлан бэлтгэж, баталгаажуулаагүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 646 дугаар тогтоолоор Буянт–Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг баталсан байна.

Тайлант хугацаанд нийт борлуулалтын орлогын төлөвлөгөөг 2 дахин буюу 748,0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Энэ нь олон хүнтэй томоохон байгууллагын шинэ жил, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах ажил эрс нэмэгдсэнтэй холбоотой. Эдгээр нь энэ байгууллагын орлогыг бүрдүүлдэг үндсэн үйл ажиллагаа нь болсон бөгөөд компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай нийцэхгүй байна.

Харин батлагдсан зардлыг 87.1 хувь буюу 874,9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь үйл ажиллагааны орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын цахим хуудас аудитын хугацаанд ажиллаагүй тул шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт өгөх боломжгүй байлаа.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 88.3 хувьтай байна.

Өнгөрсөн оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 4 байгууллагад холбогдох 6,2 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхийн байгууллагад өгч, 1 байгууллагатай авлага барагдуулах талаар гэрээ хэлцэл хийгдэж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-аар 2018 оны жилийн эцсийн тайлан санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Дотоод хяналт

3.1.1 Илрүүлэлт:

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын кассаар 2018 онд бэлэн мөнгөөр 211,5 сая төгрөгийн орлого, 198,6 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан бөгөөд эдгээр гүйлгээг хариуцаж гүйцэтгэх кассын няравын орон тоо байхгүйгээс нягтлан бодогч кассын няравын ажлыг хавсран гүйцэтгэсэн байна.

Энэ нь “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно,” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Бэлэн мөнгөний гүйлгээнд тавих дотоод хяналт алдагдаж, залилан буюу хууль бус үйлдэл гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Кассын нярвын ажил үүргийг түүнд шууд хяналт тавих эрх үүрэгтэй нягтлан бодогчоос салгаж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод

хяналтын тогтолцоог шинэчлэх саналыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлыг хүлээн зөвшөөрч холбогдох арга хэмжээ авч ажиллахаар болсон.

3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.2.1 Илрүүлэлт:

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ 2018 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулаагүй, худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлээгүй байна.

Тайлант жилд 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн боловч худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулаагүй.

Энэ нь “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48, 49 дүгээр зүйл, Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 1.2, 2.5, 3.1 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ үлдэгдэл нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж, заавар журмуудтай нийцэхгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Тайлант хугацаанд батлагдсан төсөвтэй уялдуулан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулан, гүйцэтгэлийг тайлагнах тухай зөвлөмж хүргүүлэв.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлыг хүлээн зөвшөөрч холбогдох арга хэмжээ авч ажиллахаар болсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлангийн хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	48,827,344.47	37,215,894.05
1.1.2	Дансны авлага	65,583,462.30	143,956,103.62
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	78,315,113.90	100,097,726.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		2,257,120.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	192,725,920.67	283,526,844.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	24,085,295,830.68	49,668,374,949.66
1.2.2	Биет бус хөрөнгө	2,354,166.91	460,537,083.58
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,087,649,997.59	50,128,912,033.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,280,375,918.26	50,412,438,877.37
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	28,428,103.21	52,645,908.96
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	20,743,351.45	
2.1.1.4	НДШ - ийн өглөг	968,146.23	
2.1.1.5	НӨТ-ийн өглөг	53,538,356.88	164,788,572.64
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,750,000.00	17,500,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.12	Бусад өглөг	442,046.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	111,870,003.77	234,934,481.60
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2	Өр төлбөрийн нийт дүн	111,870,003.77	234,934,481.60
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	29,362,995,053.34	29,408,582,053.34
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Эздийн өмчийн бусад хэсэг		458,640,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		25,938,458,763.97
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(5,194,489,138.85)	(5,628,176,421.54)
2.3.10	Тайлант үеийн ашиг/алдагдал		
2.3.11	Эздийн өмчийн дүн	24,168,505,914.49	50,177,504,395.77
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,280,375,918.26	50,412,438,877.37

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлангийн хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12 р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	763,627,405.65	1,463,987,237.06
2	Борлуулалтын өртөг	67,983,729.97	786,608,245.07
3	Нийт ашиг (алдагдал)	695,643,675.68	677,378,991.99
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	558,383.80	63,825.13
8	Бусад орлого		19,019,663.91
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,154,706,244.07	1,093,057,001.45
11	Санхүүгийн зардал	110,700.00	
12	Бусад зардал	4,442,046.00	2,302,000.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	63,333.33	
17	Бусад алдагдал		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(462,841,571.66)	(398,896,520.42)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(462,841,571.66)	(398,896,520.42)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(462,841,571.66)	(398,896,520.42)
24	Орлогын нийт дүн	(462,841,571.66)	(398,896,520.42)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлангийн хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	709,986,325.77	1,551,408,532.05
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	704,086,513.77	1,535,744,624.46
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,836,452.00	3,725,843.00
	Бусад мөнгөн орлого	63,360.00	11,938,064.59
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	767,252,446.35	1,546,131,326.30
	Ажиллагчдад төлсөн	206,741,884.64	206,820,778.65
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	48,677,187.15	57,799,479.76
	Бараа материал худалдан авахад төлсөн	269,929,701.20	952,189,882.71
	Ашиглалтын зардалд төлсөн	224,712,023.36	203,766,881.10
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,084,950.00	6,848,100.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		91,928,735.30
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	8,106,700.00	26,777,468.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(57,266,120.58)	5,277,205.75
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	17,558,383.80	240,714.86
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		94,500.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		110,000.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	17,000,000.00	
	Хүлээн авсан хүүний орлого	558,383.80	36,214.86
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	5,883,592.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		5,883,592.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,558,383.80	(5,642,877.14)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,600,000.00	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,600,000.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,600,000.00	
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	7,600,000.00	
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		4,039,299.03
	Төлсөн ногдол ашиг		7,206,480.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(11,245,779.03)
	Валютын ханшийн зөрүү		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(39,707,736.78)	(11,611,450.42)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,535,081.25	48,827,344.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,827,344.47	37,215,894.05

4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017-01-01-ний үлдэгдэл	29,362,995,053.34					-	(4,731,638,476.28)	24,631,356,577.06
3	Залруулсан үлдэгдэл	29,362,995,053.34	-	-	-	-	-	(4,731,638,476.28)	24,631,356,577.06
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(462,841,571.66)	(462,841,571.66)
5	2017-12-31-ний үлдэгдэл	29,362,995,053.34	-	-	-	-	-	(5,194,489,138.85)	24,168,505,914.49
6	НББ-ийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(34,790,762.27)	(34,790,762.27)
7	Залруулсан үлдэгдэл	29,362,995,053.34	-	-	-	-	-	(5,229,279,901.12)	24,133,715,152.22
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-	-	-	-	-	(398,896,520.42)	(398,896,520.42)
9	Өмчид гарсан өөрчлөлт	45,587,350.00	-	-	-	-			45,587,350.00

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

10	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	25,938,458,413.97	-	458,640,000.00		26,397,098,413.97
11	2018-12-31-ний үлдэгдэл	29,408,582,403.34	-	-	25,938,458,413.97	-	458,640,000.00	(5,628,176,421.54)	50,177,504,395.77

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019-02-25	Аудитын нэр:	Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/12/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ			Сая төгрөгөөр	

N	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5			9	10
1	Дотоод хяналт	"Буянт - Ухаа спортын ордон" ТӨААТҮГ-ын кассаар 2018 онд 211,047.4 мянган төгрөгийн орлого, 198,574.0 мянган төгрөгийн зарлагын бэлэн мөнгөний гүйлгээ гарсан бөгөөд эдгээр гүйлгээг хариуцаж гүйцэтгэх кассын няравын орон тоо байхгүйгээс байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар кассын няравын ажлыг хавсран гүйцэтгэсэн байна.	198,6	Зөвлөмж өгсөн			Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал, Нягтлан бодогч	Л.Энхбаяр, Н.Баатаргэрэл

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2	Балансын данстай холбоотой асуудал	"Буянт - Ухаа спортын ордон" ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангаар 27 харилцагчтай холбоотой 93,529.5 мянган төгрөгийн авлага, 1 харилцагчтай холбоотой 18,645.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Үүнээс шүүхийн шатанд 4 байгууллагын 6,159.5 мянган төгрөгийн авлага байна.	112,2	Албан шаардлага өгсөн			Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал, Нягтлан бодогч	Л.Энхбаяр, Н.Баатаргэрэл
3	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	"Буянт - Ухаа спортын ордон" ТӨААТҮГ 2018 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулаагүй, худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлээгүй байна.	50,0	Зөвлөмж өгсөн			Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал, Нягтлан бодогч	Л.Энхбаяр, Н.Баатаргэрэл
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа	Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй хураангуй бүртгэл, анхан шатны баримтыг иж бүрдэл, хүчин төгөлдөр байдлыг шалгахад кассын тайлан, агуулахын бүртгэл хөтлөөгүй байсныг аудитын явцад залруулсан.	615,7	Залруулсан			Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал, Нягтлан бодогч	Л.Энхбаяр, Н.Баатаргэрэл
5	Орлогын данстай холбоотой асуудал	Аудитын явцад 64 нэрийн үндсэн хөрөнгөнд хамаарах тавилга, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нягтлан бодох бүртгэл, тайланд тусгагдаагүй байсныг 45,587.4 мянган төгрөгөөр үнэлүүлж, данс бүртгэлд тусгуулав.	45,6	Залруулсан			Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал, Нягтлан бодогч	Л.Энхбаяр, Н.Баатаргэрэл
6	Балансын данстай холбоотой асуудал	Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2018 онд хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн 458,640.0 мянган төгрөгийг өмчийн дүнд оруулан тайлагнасан байсныг залруулж, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлж, залруулав.	458,6	Залруулсан			Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал, Нягтлан бодогч	Л.Энхбаяр, Н.Баатаргэрэл
		Дүн	1,480.6					

